



ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ

___ оны ___ сарын ___ өдөр

Дугаар ___

Улаанбаатар хот

Татвар төлөгчийн бүртгэлийн
журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Татварын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.7, 77 дугаар зүйлийн 77.7.3, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Татвар төлөгчийн бүртгэлийн журмыг хавсралтаар баталсугай.
2. Энэ журмыг татварын албаны хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Татварын ерөнхий газрын Татвар төлөгчтэй харилцах газар /Д.Цогзолмаа/, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Мэдээллийн технологийн газар /Д.Ган-Эрдэнэ/, Татварын ерөнхий газрын Мэдээллийн технологи, статистикийн төв /Х.Батбаяр/-д тус тус үүрэг болгосугай.
3. Журмыг хэрэгжүүлж ажиллахыг харьяа нэгжийн дарга нарт даалгасугай.
4. Журмыг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Татварын ерөнхий газрын даргын 2017 оны А/06 дугаар тушаалыг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчингүй болсонд тооцсугай.

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ БӨГӨӨД
ДЭД ДАРГА:

Б.ЗАЯАБАЛ

УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Татварын ерөнхий газрын дарга,
Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын
2019 оны ... сарын ... -ны өдрийн ... дугаар
хамтарсан тушаалын хавсралт

ТАТВАР ТӨЛӨГЧИЙН БҮРТГЭЛИЙН ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмын зорилго нь Татварын ерөнхий хуулийн 25, 26 дугаар зүйлд заасан татвар төлөх, эсхүл суутгах үүрэг бүхий этгээдийг татвар төлөгчөөрбүртгэх, татвар төлөгчийн бүртгэлийн мэдээлэлд өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Татварын алба татвар төлөгчийг бүртгэхэд дараах мэдээлэл, журмыг баримтална:

1.2.1.хуулийн этгээд, иргэнийг татвар төлөгчөөр бүртгэхдээ Засгийн газрын 2019 оны 220 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн байгууллагаас төрийн болон бусад байгууллагатай цахим хэлбэрээр мэдээлэл солилцох, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам”-д заасны дагуу Үндэсний дата төвд байршуулсан улсын бүртгэлийн байгууллагын цахим үйлчилгээний системээр дамжуулан хүлээн авсан суурь мэдээлэл;

1.2.2.хуулийн этгээдийн эрхгүй байгууллагыг бүртгэхэд Засгийн газрын 2018 оны 30 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдох, төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээд”-ийг бүртгэх эрх бүхий яам, агентлаг, Шүүхийн ерөнхий зөвлөл, дээд шүүх, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын төрөлжсөн мэдээлэл;

1.2.3.гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг татвар төлөгчөөр бүртгэхэд гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын төрөлжсөн мэдээлэл;

1.2.4.Монгол Улсын хуулийн этгээдийн гадаад улсад байгуулсан салбар, төлөөлөгчийн болон төлөөний газрыг бүртгэхэд татвар төлөгчийн мэдүүлсэн мэдээлэл;

1.2.5.гадаад улсын элчин сайдын яам, дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллага, түүнд ажиллаж байгаа дипломат эрх бүхий хувь хүнийг татвар төлөгчөөр бүртгэх асуудлыг Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу;

1.2.6.төлөөний газрыг татвар төлөгчөөр бүртгэхэд татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын баталсан “Төлөөний газрыг бүртгэх, бүртгэлээс хасах, албан татвар төлөх, тайлагнах журам”;

1.2.7.Монгол Улсад байнга болон түр оршин суугч татвар төлөгч хувь хүнийг бүртгэхдээ татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын баталсан “Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгч болон Монгол Улсын оршин суугч бус албан татвар төлөгчийг тодорхойлох, бүртгэх, бүртгэлээс хасах, албан татварын тооцоо хийх журам”.

1.3.Татвар төлөх, суутган төлөх үүрэг бүхий хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага, иргэнийг татварын алба татвар төлөгчөөр бүртгэхдээ энэ журмын 2 дугаар зүйлд заасны дагуу татвар төлөгчийн дугаар, цахим гэрчилгээ олгож, хувийн хэрэг нээнэ.

1.4.Татварын алба нь татвар төлөгчийн бүртгэлийн үйл ажиллагааны цахим программ хангамжтай байна.

1.5.Татвар төлөгч нь Татварын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.5-д заасны дагуу мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцна.

1.6.Улсын бүртгэлийн асуудал хариуцсан байгууллага нь иргэн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага, түүний удирдлага, эрх бүхий албан тушаалтны

цахим шуудангийн хаяг, гар утасны дугаарыг тэдгээрийн бүртгэл, түүний өөрчлөлтийн мэдээлэлд тухай бүр бүртгэнэ.

1.7.Татварын албанд бүртгүүлээгүй татвар төлөх үүрэг бүхий этгээдийг татварын улсын байцаагч илрүүлсэн бол Зөрчлийн тухай хуульд заасны дагуу хариуцлага тооцож, татвар төлөгчөөр бүртгэх ажлыг энэ журмын дагуу зохион байгуулна.

Хоёр.Татвар төлөгчийг бүртгэж, татвар төлөгчийн дугаар, гэрчилгээ олгох, хувийн хэрэг хөтлөх

2.1.Хуулийн этгээдийг татвар төлөгчөөр бүртгэхдээ дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

2.1.1.татварын алба нь энэ журмын 1.2.1-д заасан мэдээлэлд үндэслэн хуулийн этгээдийг татвар төлөгчөөр бүртгэнэ;

2.1.2.бүртгэх эрх бүхий байгууллагад шинээр бүртгүүлсэн хуулийн этгээдийн мэдээлэл нь татварын албаны ТБМНС-д илгээгдсэн тухай бүр татварын албанаас татварын нэгдсэн мэдээллийн системд нэвтрэх нэр, нууц үгийг бүртгэлтэй гар утас, цахим хаягаар илгээнэ;

2.1.3.татвар төлөгч татварын нэгдсэн мэдээллийн системд бүртгэлийн мэдээллээ баталгаажуулснаар татварын алба ТБМНС-д бүртгэж татвар төлөгчийн дугаар, цахим гэрчилгээ олгоно;

2.1.4.газар эзэмших, ашиглах эрхтэй хуулийн этгээд Татварын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.10-д заасны дагуу татварын албанд бүртгүүлэх бөгөөд мөн хуулийн 26 дугаар зүйлийн 26.11-д заасны дагуу өөрийн болон эцсийн эзэмшигчийн өөрчлөлтийн мэдээллийг 30 хоногийн дотор харьяалах татварын албанд хавсралт маягтын дагуу бүртгүүлнэ;

2.1.5.ашигт малтмал, газрын тос, цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд Татварын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.10-д заасны дагуу татварын албанд бүртгүүлэх бөгөөд мөн хуулийн 26 дугаар зүйлийн 26.11-д заасны дагуу өөрийн болон эцсийн эзэмшигчийн өөрчлөлтийн мэдээллийг 30 хоногийн дотор харьяалах татварын албанд хавсралт маягтын бүртгүүлнэ;

2.1.6.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6-д зааснаар эцсийн өмчлөгчийн мэдээлэл өөрчлөгдсөн тохиолдолд улсын бүртгэлийн байгууллага холбогдох татвар төлсөн талаарх татварын албаны тодорхойлолтыг үндэслэн өөрчлөлтийг бүртгэнэ.

2.1.7.хуулийн этгээд нь Компанийн тухай хуулийн 19, 21, 22 дугаар зүйлд заасны дагуу нийлүүлэх, хуваах, тусгаарлах замаар шинээр үүсгэн байгуулагдсан тохиолдолд энэ журмын 2.1.1, 2.1.2, 2.1.3-т заасны дагуу бүртгүүлнэ.

2.2.Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д зааснаас бусад татварын хуулийн дагуу татвар төлөх, татвар суутган төлөх үүрэг бүхий хуулийн этгээдийн эрхгүй байгууллагыг бүртгэхдээ дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

2.2.1.хуулийн этгээдийн эрхгүй байгууллагын үүсгэн байгуулагч, гүйцэтгэх удирдлага, төлөөлөх эрх бүхий албан тушаалтны ирүүлсэн хүсэлтийг татварын алба хянан шийдвэрлэж, ТБМНС-д мэдээллийг бүртгэн татвар төлөгчийн татварын нэгдсэн мэдээллийн системд нэвтрэх нэр, нууц үгийг бүртгэлтэй гар утас, цахим хаягаар илгээнэ;

2.2.2.татварын нэгдсэн мэдээллийн системд татвар төлөгчийн бүртгэлийн мэдээллээ баталгаажуулснаар татварын алба ТБМНС-д бүртгэж татвар төлөгчийн дугаар, цахим гэрчилгээ олгоно;

2.2.3.бүртгэх эрх бүхий байгууллага, ТБМНС-ийн мэдээллийг үндэслэн хуулийн этгээдийн эрхгүй байгууллагад татвар төлөгчөөр бүртгүүлэх мэдэгдэл хүргүүлж болно;

2.2.4.хуулийн этгээдийн эрхгүй байгууллагад мэдэгдэл хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор энэхүү журмын 2.2.1, 2.2.2-т заасны дагуу татвар төлөгчөөр бүртгүүлнэ.

2.3.Үйл ажиллагааны удирдлагыг Монгол Улсаас хэрэгжүүлдэг гадаадын аж ахуйн нэгж /цаашид “гадаадын аж ахуйн нэгж” гэх/-ийг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4, мөн хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д заасан нөхцөлийг хангасан тохиолдолд татвар төлөгчөөр бүртгэхдээ дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

2.3.1.гадаадын аж ахуйн нэгжийн харилцан хамаарал бүхий Монгол Улсад байнга оршин суугч хувь хүн, хуулийн этгээд нь өөрийн эзэмшдэг гадаадын аж ахуйн нэгжийн мэдээллийг татварын албанд өөрөө бүртгүүлнэ;

2.3.2.татварын алба нь мэдээлэл солилцооны хүрээнд авсан мэдээлэлд үндэслэн энэ журмын 2.3.1-д заасан этгээдэд мэдэгдэл хүргүүлнэ;

2.3.3.энэ журмын 2.3.1-д заасан этгээд нь мэдэгдэл хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор татвар төлөгчөөр бүртгүүлнэ;

2.3.4.татварын алба нь энэ журмын 2.2.1, 2.2.2-т заасан журмын дагуу татвар төлөгчөөр бүртгэнэ.

2.4.Хувь хүнийг татвар төлөгчөөр бүртгэхдээ дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

2.4.1.иргэн татвар төлөгчөөр бүртгүүлэх хүсэлтээ татварын албанд гаргана;

2.4.2.татварын алба татвар төлөгчийн хүсэлтийг ажлын 3 хоногт багтаан Улсын бүртгэлийн цахим мэдээллийн сангийн мэдээлэлтэй тулган шийдвэрлэж, иргэний татварын цахим системд нэвтрэх нэр, нууц үгийг бүртгэлтэй гар утас, цахим хаягаар илгээнэ;

2.4.3.татварын нэгдсэн мэдээллийн системд татвар төлөгчийн бүртгэлийн мэдээллээ баталгаажуулснаар системээс татвар төлөгчийн дугаар олгон татвар төлөгчөөр бүртгэж, татвар төлөгчийн цахим гэрчилгээ олгоно;

2.4.4.татварын алба нь ТБМНС дахь мэдээлэлд үндэслэн татвар төлөгчөөр бүртгүүлэх мэдэгдэл хувь хүнд илгээж болно;

2.4.5.хувь хүн мэдэгдэл хүлээн авснаас 7 хоногийн дотор энэхүү журмын 2.4.2, 2.4.3-т заасны дагуу татвар төлөгчөөр бүртгүүлнэ;

2.4.6.Татварын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу татварын алба татвар төлөх үүрэг бүхий хувь хүнийг ТБМНС-д бүртгэж болно;

2.4.7.гадаадын иргэнийг Татварын ерөнхий хуулийн 25 дугаар зүйлийн 25.2, 25.5, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5-д заасныг баримтлан татвар төлөгчөөр бүртгэж, дугаар олгоно.

2.5.Энэ журмын 1.3-т заасан татвар төлөгчийн дугаар нь дараах шаардлагыг хангасан байна:

2.5.1.татвар төлөгчийн дугаарыг нэг удаа олгох бөгөөд хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага, хувь хүний хувьд 11 оронтой, салбар, төлөөлөгчийн газрын хувьд 14 оронтойдахин давтагдашгүй тоо байх;

2.5.2.татвар төлөгч нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасан анхан шатны баримт, гэрээ хэлцэлд татвар төлөгчийн дугаарыг тусгах;

2.5.3.харилцан хамаарал.

2.6.Татвар төлөгчийн хувийн хэрэг нь татвар төлөгчийн бүртгэл, тайлан, татвар төлөлт, буцаан олголт, суутган тооцоолол, хяналт шалгалт, эрсдэлийн тооцоолол, татварын албанд гаргасан санал, хүсэлт, гомдол, хөнгөлөлт, чөлөөлөлтийн материал, татвар төлөгчийн талаарх бусад аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүнээс ирүүлсэн тодорхойлолт, лавлагаа, мэдээлэл зэрэг татварын үйл ажиллагаатай холбоотой баримт бичгээс бүрдэнэ.

2.7.Татвар төлөгчийг шинээр бүртгэсэн өдрөөс хувийн хэргийг цахим эсхүл цаасан хэлбэрээр хөтлөх бөгөөд татвар төлөгч нэг хувийн хэрэгтэй байна.

2.8.татвар төлөгч өөр албанд шилжихэд түүний хувийн хэргийг тухайн албанд шилжүүлж өгнө.

2.9.Татвар алба нь “Татвар төлөгчийн гэрчилгээ”-г хавсралтаар батлагдсан маягтын дагуу цахим хэлбэрээр олгох бөгөөд татвар төлөгч хэвлэн авах боломжтойгоор татварын нэгдсэн мэдээллийн системд байршуулна.

2.10.Татвар төлөгчийн гэрчилгээнд дараах тэмдэглэгээ хийж өөрчлөлтийг ТБМНС-д бүртгэнэ:

2.10.1.татвар төлөгчийн бүртгэл, татварын төрлийн бүртгэлд бүртгэгдсэн, хасагдсан, өөрчлөлт орсон тухай бүр;

2.10.2.татвар төлөгчийн бүртгэлээс хасагдсан тохиолдолд гэрчилгээг хүчингүй болгох;

2.10.3.хууль тогтоомжид заасныдагуу тухайн татварын төрлөөр тусгайлсан гэрчилгээг олгож болно.

2.11.Татварын алба нь Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийгүндэслэн татвар төлөгчийн татварын төрлийн бүртгэл, түүний өөрчлөлт, хасалтыг дараах байдлаар ТБМНС-д бүртгэнэ:

2.11.1.хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага /аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлөх үндэслэлтэй бол/ нь татвар төлөгчөөр бүртгүүлж, татвар төлөгчийн дугаар олгогдсон өдрөөс эхлэн аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлөгчөөр, мөн цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын албан татвар суутган төлөгчөөр, хувь хүн нь орлогын албан татвар төлөгчөөр;

2.11.2.энэ журмын 1.2.1, 1.2.2-т заасан мэдээллийг үндэслэн татвар төлөгчийг хөрөнгийн албан татвар төлөгчөөр;

2.11.3.татвар төлөгчийн өмчлөх эрхээ бусдад шилжүүлсэн мэдээллийг үндэслэн шинэ эзэмшигчийг хөрөнгийн албан татвар төлөгчөөр бүртгэх ба хуучин эзэмшигч нь өөр төрлийн хөрөнгөгүй бол тухайн төрлийн татвар төлөгчийн бүртгэлийн хасалтыг ТБМНС-д;

2.11.4.төлбөр, хураамжийг төсөвт төвлөрүүлэх, тайлагнах үүрэг бүхий төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага нь төлбөр, хураамж суутган төлөгчөөр;

2.11.5.ашигт малтмалын нөөц ашигласны, агаарын бохирдол, ус бохирдуулсны, үйлдвэрлэлийн зориулалттай ус ашигласны болон зам ашигласны зэрэг төлбөр, хураамжийг төлөх, тайлагнах үүргийг хуулиар хүлээсэн этгээд тухайн төрлийн төлбөр, хураамж төлөгчөөр тус тус бүртгүүлнэ;

2.11.6.Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлэх татвар төлөгчийг “Нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчийг бүртгэх, бүртгэлээс хасах журам”-аар зохицуулах;

2.11.7.энэ журмын 2.11.2, 2.11.3, 2.11.4, 2.11.5, 2.11.6-д зааснаас бусад татварын хувьд тухайн төрлийн татварын хуулиар татвар төлөх үүрэг үүссэн өдрөөс эхлэн татвар төлөгч нь тухайн төрлөөр бүртгүүлэх хүсэлт гаргах;

2.11.8.татвар төлөгч нь нэг татварын албанд үндсэн татварын төрлөөр бүртгэлтэй байх бөгөөд бусад татварын албанд Төсвийн тухай хуульд заасан орон нутгийн татварын орлогын төрлөөс хамаарч тухайн татварын төрлөөр;

2.11.9.татвар төлөгч нь тухайн татварын хуулиар татвар төлөх үүрэг үүссэн бол татварын төрлөөр бүртгүүлэх хүсэлтээ цахим, эсхүл цаасан хэлбэрээр харьяалах татварын албанд гаргана. Хүсэлт ирүүлээгүй татвар төлөгчид татварын албанаас татварын төрлөөр бүртгүүлэх мэдэгдэл хүргүүлэх;

2.11.10.Татварын ерөнхий хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан үндэслэлээр тухайн төрлийн татвар төлөх үүрэг дуусгавар болсон тохиолдолд холбогдох баримт бичгийн бүрдлийг үндэслэн тухайн татварын төрлийн бүртгэлээс хасах;

2.11.11.энэ журмын 2.11.10-д заасны дагуу тухайн татварын төрлөөс хасагдсан татвар төлөгч нь татвар ногдох зүйлтэй болсон, эсхүл татвар ногдох зүйл өмчлөх, эзэмших, ашиглах эрх үүсвэл хасагдсан татварын төрлөөр дахин бүртгүүлэх;

2.11.12.татвар төлөгч нь хуулиар хүлээсэн үүргийн дагуу татварын төрлийн бүртгэлд бүртгүүлээгүй нь тухайн татварыг төлөх үүргээс чөлөөлөгдөхгүй;

2.11.13.татвар төлөгчийг татварын төрлийн бүртгэлээс хасахдаа “Татварын төрлийн бүртгэлээс хасах карт”-ыг хөтөлнө.

2.12.Татвар төлөгчийн бүртгэлийн мэдээллийн сан нь Засгийн газрын 2018 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээг ашиглах журам”-ын дагуу цахимаар солилцсон мэдээлэл, Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлд заасны дагуу төрийн болон бусад үүрэг бүхий байгууллагаас гаргуулан авсан болон татварын албанд бүрдүүлсэн дараах мэдээллээс бүрдэх бөгөөд энэ сан нь ТМБНС-ийн бүрэлдэхүүн байна:

2.12.1.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын мэдээлэл:

2.12.1.1.хуулийн этгээдийн бүртгэлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2.12.1.2.хуулийн этгээдийн оноосон нэр, регистрийн дугаар, бүртгүүлсэн он, сар, өдөр, үүсгэн байгуулсан хэлбэр, хариуцлагын хэлбэр, өмчийн хэлбэр;

2.12.1.3.хөрөнгийн хэмжээ буюу дүрмийн сан;/мөнгөн хөрөнгийн дүн /төгрөгөөр/, биет хөрөнгийн дүн /төгрөгөөр/, биет бус хөрөнгийн дүн /төгрөгөөр//

2.12.1.4.үүсгэн байгуулагч гишүүдийн мэдээлэл;/хувь хүний регистрийн дугаар, ургийн овог, эцэг, эхийн нэр, өөрийн нэр, оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ /төгрөгөөр/, хөрөнгө оруулалтын эзлэх хувь/

2.12.1.5.эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллын дагуу эрхлэх үйл ажиллагааны чиглэл, үндсэн болон туслах үйл ажиллагаа, тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, түүний дугаар, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн эцсийн эзэмшигчийн мэдээлэл, тэдгээрийн өөрчлөлтийн мэдээлэл;

2.12.1.6.үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээ, газар эзэмшлийн байдал, газар эзэмших, ашиглах эрхтэй хуулийн этгээдийн эцсийн эзэмшигчийн мэдээлэл, үндсэн болон эргэлтийн хөрөнгийн хэмжээ, хөрөнгийн гэрчилгээний дугаар;

2.12.1.7.хөрөнгө оруулагч болон харьяа салбар нэгжийн нэр, тэдгээрийн хаяг, байршил, харилцах утасны дугаар;

2.12.1.8.харилцагч банкны нэр, дансны нэр, харилцах дансны дугаар, дансны төрөл, валютын төрөл;

2.12.1.9.удирдлагын мэдээлэл;/хувь хүний регистрийн дугаар, ургийн овог, эцэг, эхийн нэр, өөрийн нэр, албан тушаал/

2.12.1.10.хуулийн этгээдийн ерөнхий захиргаа оршин байгаа хууль, ёсны хаягийн мэдээлэл /аймаг, дүүргийн нэр, сум, хорооны нэр, баг, гудамж, хорооллын нэр, байр, хаалга, хашааны дугаар/, харилцах утасны дугаар, факс, шуудангийн хаяг, цахим шуудангийн хаяг;

2.12.1.11.харилцан хамаарал бүхий этгээдийн мэдээлэл:

2.12.1.11.1.Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.8-д заасан группд хамаарах этгээд;

2.12.1.11.2.хувьцаа, хувь оролцоо, эсхүл саналын эрхийн 20 ба түүнээс доошгүй хувийг шууд болон шууд бусаар эзэмшдэг этгээд;

2.12.1.11.3.ашиг, эсхүл татан буугдсаны дараах үлдэгдэл хөрөнгөөс 20 ба түүнээс доошгүй хувийг шууд болон шууд бусаар хүртэх эрхтэй этгээд;

2.12.1.11.4.хувьцаа, хувь оролцоо, эсхүл саналын эрхийн 20 ба түүнээс доошгүй хувийг гуравдагч этгээд шууд болон шууд бусаар эзэмшдэг аж ахуйн нэгж;

2.12.1.11.5.ашиг, эсхүл татан буугдсаны дараах үлдэгдэл хөрөнгөөс 20 ба түүнээс доошгүй хувийг гуравдагч этгээд шууд болон шууд бусаар хүртэх эрхтэй аж ахуйн нэгж;

2.12.1.11.6.Татварын ерөнхий хуулийн хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1-д заасан этгээдийн шууд болон шууд бус эзэмшил дэх энэ хуулийн 27.1.3, 27.1.4, 27.1.5, 27.1.6-д заасан харилцаа бүхий этгээд;

2.12.1.11.7.Татварын ерөнхий хуулийн хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1-д заасан этгээдийн шууд болон шууд бус эзэмшил дэх энэ хуулийн 27.1.3, 27.1.4, 27.1.5, 27.1.6-д заасан харилцаа бүхий этгээд;

2.12.1.11.8.Татварын ерөнхий хуулийн хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д заасан этгээд болон харилцан хамаарал бүхий аж ахуйн нэгжийн салбар, төлөөний газар зэрэг.

2.12.1.12.Монгол Улсад оршин суугч татвар төлөгчийн татвар ногдуулах орлогыг бууруулах, алдагдлыг өсгөх үндсэн зорилгоор харилцаа тогтоосон этгээд;

2.12.1.13.хуулийн этгээд татан буугдсан тухай мэдээлэл;/Татан буугдсан тухай шийдвэрийн нэр, он, сар, өдөр, улсын бүртгэлээс хассан тухай бичиг баримт/

2.12.1.14.Татварын ерөнхий хуулийн хуулийн дээрх заалттай адилтгах бусад этгээд;

2.12.1.15.Монгол Улс болон гадаад улсад байгуулсан салбар, төлөөлөгчийн газрын мэдээлэл болон эцсийн өмчлөгч, тэдгээрийн хувь, оролцоо, хөрөнгийн мэдээлэл;

2.12.1.16.холбогдох бусад мэдээлэл.

2.12.2.Монгол Улсын иргэний дэлгэрэнгүй мэдээлэл:

2.12.2.1.бүртгэсэн байгууллагын мэдээлэл, хувь хүний регистрийн дугаар, ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр, хувь хүний харьяалал, иргэний үнэмлэх болон гадаад паспортын дугаар;

2.12.2.2.харилцагч банкны нэр, дансны нэр, харилцах дансны дугаар, дансны төрөл, валютын төрөл;

2.12.2.3.оршин суугаа хаягийн мэдээлэл /аймаг, дүүрэг, сум, хороо, баг, гудамж, хорооллын нэр, байр, хаалга, хашааны дугаар/, харилцах утасны дугаар, факс, шуудангийн хаяг, цахим шуудангийн хаяг;

2.12.2.4.харилцан хамаарал бүхий этгээдийн мэдээлэл; /татвар төлөгчийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, хүүхэд, өвөг эцэг, эмэг эх, ач, зээ болон эхнэр /нөхөр/, хамтран амьдрагч, тэдгээрийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү/

2.12.2.5.хувь хүн нас барсан, нас барсанд тооцогдсон мэдээлэл./нас барсныг нотлох баримт бичиг, нас барсан он, сар, өдөр, улсын бүртгэлээс хассан бичиг баримт/

2.12.3.хөрөнгийн бүртгэлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2.12.3.1.үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл, түүний өөрчлөлтийн мэдээлэл;/өмчлөгчийн мэдээлэл, гэрчилгээний дугаар, хөрөнгийн үнэлгээ, хэмжээ /метр квадратаар/, эзэмшиж эхэлсэн огноо, хамтран өмчлөгчийн мэдээлэл, өмчлөх эрх бүртгэхэд үндэслэл, шийдвэр, гэрээ хэлцэл, барьцаа, битүүмжлэлийн талаарх мэдээлэл/

2.12.3.2.газрын эзэмших, ашиглах эрхийн бүртгэл, түүний өөрчлөлтийн мэдээлэл; /эзэмшигч, ашиглагчийн мэдээлэл,гэрчилгээний дугаар, бүртгэлийн үнэлгээ, хэмжээ /га-гаар/, өмчлөн эхэлсэн огноо, хамтран эзэмшигч, ашиглагчийн мэдээлэл, эрх олгох, шилжүүлэх үндэслэл, шийдвэр, гэрээ, хэлцэл/

2.13.хуулийн этгээдийн эрхгүй байгууллагыг бүртгэх эрх бүхий байгууллагын мэдээлэл:

2.13.1.бүртгэсэн байгууллагын мэдээлэл, бүртгэсэн гэрчилгээний дугаар, бүртгүүлсэн он, сар, өдөр;

2.13.2.хуулийн этгээдийн эрхгүй байгууллагын оноосон нэр, бүртгэлийн дугаар, бүртгүүлсэн он, сар, өдөр, хариуцлагын хэлбэр, өмчийн хэлбэр, салбарын мэдээлэл;

2.13.3.хөрөнгийн дүн буюу дүрмийн сан; /мөнгөн хөрөнгийн дүн /төгрөгөөр/, биет хөрөнгийн дүн /төгрөгөөр/, биет бус хөрөнгийн дүн /төгрөгөөр/

2.13.4.удирдлагын мэдээлэл;/хувь хүний регистрийн дугаар, ургийн овог, эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал/

2.13.5.үүсгэн байгуулагч гишүүдийн мэдээлэл;/хувь хүний регистрийн дугаар, ургийн овог, эцэг, эхийн нэр, нэр, хөрөнгө оруулалтын хэмжээ /төгрөгөөр/, хөрөнгө оруулалтын хувь/

2.13.6.эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллаар эрхлэх үйл ажиллагааны чиглэл, үндсэн болон туслах үйл ажиллагаа, тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрлийн дугаар, тэдгээрийн өөрчлөлтийн мэдээлэл;

2.13.7.хөрөнгө оруулагч болон харьяа салбар нэгжийн нэр, тэдгээрийн хаяг, байршил, харилцах утасны дугаар;

2.13.8.харилцагч банкны нэр, дансны нэр, харилцах дансны дугаар, дансны төрөл, валютын төрөл;

2.13.9.байгууллагын ерөнхий захиргаа оршин байгаа хууль, ёсны хаягийн мэдээлэл /аймаг, хот, сум, дүүрэг, баг, хороо, гудамж, хорооллын нэр, байр, хаалга, хашааны дугаар/, харилцах утасны дугаар, факс, шуудангийн хаяг, цахим шуудангийн хаяг;

2.13.10.үйл ажиллагааны удирдлагыг Монгол Улсаас хэрэгжүүлдэг гадаад аж ахуйн нэгжийн мэдээлэл;

2.13.11.харилцан хамаарал бүхий этгээдийн мэдээлэл, гадаад улсад байгуулсан салбар, төлөөлөгчийн газрын мэдээлэл болон эцсийн өмчлөгч, тэдгээрийн хувь, оролцоо, хөрөнгийн мэдээлэл;

2.13.12.хуулийн этгээдийн эрхгүй байгууллагыг татан буулгасан мэдээлэл./Татан буугдсан тухай шийдвэрийн нэр, он, сар, өдөр, эрх бүхий байгууллагын татан буулгасан тухай бичиг баримт/

2.14.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын мэдээлэл:

2.14.1.гадаадын иргэн, харьяалалгүй хүний паспорт, түүнтэй адилтгах баримт бичиг;

2.14.2.бүртгэсэн эрх бүхий байгууллагын мэдээлэл, оршин суух үнэмлэхийн мэдээлэл;

2.14.3.Монгол Улсад харилцагч банкны нэр, дансны нэр, харилцах дансны дугаар, дансны төрөл, валютын төрөл;

2.14.4.оршин суугаа хаягийн мэдээлэл /аймаг, дүүрэг, сум, хороо, баг, гудамж, хорооллын нэр, байр, хаалга, хашааны дугаар/, харилцах утасны дугаар, факс, шуудангийн хаяг, цахим шуудангийн хаяг.

2.15.Автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын мэдээлэл:

2.15.1.автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн бүртгэл, түүний өөрчлөлтийн мэдээлэл; /өмчлөгчийн мэдээлэл, улсын бүртгэлийн дугаар, тээврийн хэрэгслийн гэрчилгээний дугаар, төрөл, марк, арлын дугаар, ангилал, хөдөлгүүрийн багтаамж, даац /тонноор/, эзэмшиж эхэлсэн огноо/

2.16.Цагдаагийн байгууллагын мэдээлэл:

2.16.1.галт зэвсгийн мэдээлэл; /Өмчлөгч, эзэмшигчийн мэдээлэл, галт зэвсгийн гэрчилгээний дугаар, галт зэвсгийн дугаар, төрөл, марк, зориулалт, гол төмрийн голч хэмжээ /миллиметрээр/, эзэмшиж эхэлсэн огноо/

2.17.Статистикийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын мэдээлэл:

2.17.1.малын мэдээлэл; /Бүртгэгдсэн эрх бүхий этгээдийн мэдээлэл, малчин өрх, мал бүхий этгээдийн нэр, регистрийн дугаар, байршил, аймаг, сум, дүүрэг, баг, хорооны нэр, малын тоо толгой, адуу, үхэр, тэмээ, хонь, ямааны тоо, мөн эдгээрийг хонин толгойд шилжүүлсэн тоо/

2.18.Оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага:

2.18.1.Биет бус хөрөнгийн мэдээлэл; /Бүртгэгдсэн эрх бүхий этгээдийн мэдээлэл, гэрчилгээний дугаар, хөрөнгийн нэр, ангилал, тоо, ширхэг, хөрөнгө эзэмших хугацаа /жилээр/, эзэмшиж эхэлсэн огноо/

2.19.Бусад төрийн захиргааны болон бусад байгууллагыг мэдээлэл:

2.19.1.бусад хөрөнгийн холбогдох мэдээлэл; /хөрөнгө оруулалт, үнэт цаас, хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийн талаарх мэдээлэл, тэдгээрийн хэмжээ, үнэ, тархалтын тухай мэдээлэл/

2.20.Татварын албаны мэдээлэл:

2.20.1.татварын албанд татвар төлөгчөөр бүртгүүлсэн он, сар, өдөр, татвар төлөгчийн эрхэлж буй үйл ажиллагааны хаяг, байршлын мэдээлэл, харилцах утасны дугаар, факс, шуудангийн хаяг, цахим шуудангийн хаяг;

2.20.2.энэхүү журмын 2.1.1.8-д зааснаас бусад удирдлагын мэдээлэл, нягтлан бодогчийн мэдээлэл;

2.20.3.ажлын байрны мэдээлэл; /ажлын байрны тоо, ажлын байрны хаяг, газрын зурагт байрлах байршлын цэгийн мэдээлэл, ажилчдын тоо, ажилтны татвар төлөгчийн дугаар, регистрийн дугаар, ургийн овог, эцэг, эхийн нэр, өөрийн нэр/

2.20.4.татвар төлөгчийн харилцан хамаарал бүхий этгээдийн мэдээлэл:

2.20.4.1.хувь нийлүүлэгчид шууд болон шууд бусаар аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны шийдвэр гаргахад нэгдмэл байр суурьтай оролцохоор хэлцэл байгуулж, уг хэлцлийн үндсэн дээр шийдвэр гаргадаг бол тухайн хувь нийлүүлэгч этгээдийг Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.3, 27.1.4, 27.1.5, 27.1.6-д заасан хувь, оролцооны хувьд нэг этгээдийн мэдээлэл;

2.20.4.2.шууд бус оролцоог тодорхойлохдоо шууд оролцооны хувиудын үржвэрээр тодорхойлно. Шууд оролцоо нь 50 хувиас дээш байвал 100 хувийн оролцоотой этгээдийн мэдээлэл.

2.20.5.татвар төлөгчийг хуулийн дагуу эдэлсэн хөнгөлөлт, чөлөөлөлтийн мэдээлэл;

2.20.6.газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээтэй болон ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн эцсийн эзэмшигчийн мэдээлэл;

2.20.7.татварын тайлан, татварын хяналт шалгалтын нөхөн ногдуулалтын акт, түүний хамааралтай баримт бичгүүд, өрийн барагдуулалт, буцаан олголт, суутган тооцоолол, урамшуулалтай холбоотой татварын албанаас үйлдэх баримт бичиг;

2.20.8.татвар төлөгчийн татварын төрөл, татварын ногдуулалт, төлөлт, татварын тооцооллын мэдээлэл;

2.20.9.татварын албанаас олгосон шагналын мэдээлэл;

2.20.10.хөрөнгө оруулалтын гэрчилгээ, гэрээ болон тогтвортой байдлын гэрээ байгуулсан мэдээлэл;

2.20.11.татварын албанаас авсан тодорхойлолтын мэдээлэл;

2.20.12.гадаадын аж ахуйн нэгжийн төлөөний газрын мэдээлэл;

2.20.13.татвар ногдуулах зорилгоор бусад байгууллагаас ирүүлсэн мэдээлэл.

2.21.Татвар төлөгчөөс ирүүлсэн мэдээлэл:

2.21.1.энэ журмын 2.12,2.13,2.14,2.15,2.16,2.17,2.18,2.19,2.20-д заасан мэдээллийн нэмэлт, өөрчлөлт;

2.21.2.татварын албанд ирүүлсэн санал, хүсэлт, мэдээлэл, гомдол;

2.21.3.татварын албанд өөрчлөн мэдүүлсэн хаяг, байршил, харилцах утасны дугаар, цахим шуудангийн хаяг;

2.21.4.бусад мэдээлэл.

2.22.татварын төрлөөс түдгэлзүүлэх гэдгийг эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийн дагуу тодорхой хугацаанд тухайн татварын төрлөөр тайлагнах үүргээс чөлөөлөгдсөнийг ойлгох бөгөөд татварын алба шийдвэрт заасан хугацаагаар дараах байдлаар татварын төрлөөс түдгэлзүүлэх:

2.22.1.1.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т заасны дагуу 2-6 сар хүлээгдэж буй татвар төлөгчдийг холбогдох баримт бичгийн бүрдлийг үндэслэн тухайн татварын төрлийг түдгэлзүүлэх өөрчлөлтийг ТБМНС-д оруулах;

2.22.1.2.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3-т заасны дагуу хуулийн этгээдийг татан буулгахаар шүүхэд нэхэмжлэл гаргасан тохиолдолд шүүхийн шийдвэр гарах хүртэлх хугацаанд холбогдох баримт бичгийн бүрдлийг үндэслэн тухайн татварын төрлийг түдгэлзүүлэн, ТБМНС-д бүртгэнэ. Хэрэв шүүх тухайн хуулийн этгээдийг татан буулгах үндэслэлгүй гэж үзвэл татвар төлөгчийн бүртгэлийг сэргээх;

2.22.1.3.эрх, тусгай зөвшөөрлийг тухайн байгууллагад олгосон эрх бүхий бүхий байгууллагын шийдвэрээр түдгэлзүүлсэн хугацаанд тухайн татварын төрлөөс түр түдгэлзүүлэн ТБМНС-д бүртгэнэ;

2.22.1.4.хэрвээ түдгэлзүүлсэн хугацаанд тухайн татварын төрлөөр татвар ногдуулах орлого олсон, эсхүл татвар ногдох зүйлийг өмчлөгч, эзэмшигч, ашиглагч бол татварын тайланг нөхөн тайлагнах бөгөөд татвар төлөх үүргээс чөлөөлөгдөхгүй.

2.23.Татвар төлөгчийн ангилал, татварын албаны харьяаллыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга тогтооно.

Гурав.Татвар төлөгчийн бүртгэлийн мэдээлэлд өөрчлөлт оруулах

3.1.Татвар төлөгчийн бүртгэлийн мэдээлэлд дараах байдлаар өөрчлөлт оруулна:

3.1.1.татвар төлөгчийн хүсэлтээр;

3.1.2.хөндлөнгийн мэдээлэлд үндэслэн;

3.1.3.эрх бүхий байгууллагын шийдвэрээр;

3.1.4.татварын улсын байцаагч ажил үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн мэдээллээр /Татвар төлөгчийн хаяг, байршлын мэдээлэл, харилцах утасны дугаар, факс, шуудангийн хаяг, цахим шуудангийн хаяг, үйл ажиллагаа эрхэлсэн байдал, үйл ажиллагааны төрөл гэх мэт/;

3.1.5.хуульд заасан бусад үндэслэлээр.

3.2.Татвар төлөгч нь ТБМНС-д бүртгэгдсэн мэдээллийг баталгаажуулах, эсвэл өөрчлөлтийг бүртгүүлэхээр цахим хүсэлт илгээнэ. Татварын алба мэдээллийг нягтлан өөрчлөлтийг ТБМНС-д бүртгэх ба хуучин мэдээллийг хадгална.

3.3.Татвар төлөгч нь бүртгэлийн мэдээлэлд нэмэлт өөрчлөлт хийлгэх хүсэлтийг холбогдох баримт бичгийн хамт цаасан хэлбэрээр ирүүлж болно. Татварын алба энэхүү мэдээллийн өөрчлөлтийг ТБМНС-д бүртгэнэ.

3.4.Татварын алба нь хөндлөнгийн мэдээллийн сангийн мэдээлэлд үндэслэн татвар төлөгчийн бүртгэлийн мэдээлэлд өөрчлөлт оруулах талаар татвар төлөгчид бүртгэлтэй гар утас болон цахим шуудангийн хаягаар нь мэдэгдэнэ. Татвар төлөгч нь мэдэгдсэнээс

хойш 7 хоногийн дотор мэдээллээ баталгаажуулах бөгөөд баталгаажуулаагүй нь аливаа хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

3.5.Татварын алба нь Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлд заасан байгууллагаас ирүүлсэн мэдээллийг үндэслэн татвар төлөгчийн бүртгэлийн мэдээлэлд өөрчлөлт оруулахыг татвар төлөгчид мэдэгдэнэ.

3.6.Татварын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.6-д заасан хугацаанд татвар төлөгчийн бүртгэлийн мэдээллийн өөрчлөлтийг баталгаажуулаагүй тохиолдолд эрсдэлтэй гэж үзэн хувийн хэрэгт бүртгэнэ.

3.7.Татвар төлөгч нь Татварын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.3-т заасан мэдээллийн өөрчлөлтийг 7 хоногийн дотор ТБМНС-д өөрөө бүртгүүлэх, эсхүл татварын албанаас мэдэгдсэнээр мөн хугацаанд баталгаажуулах үүргийг хүлээж татвар төлөгчийн гэрчилгээнд тэмдэглүүлнэ.

3.8.Энэ журмын 2.1.4, 2.1.5-д заасан мэдээллийн өөрчлөлтийг Татварын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.12-д заасан хугацаанд татварын албанд бүртгүүлнэ.

3.9.Татвар төлөгчийн болон татвар ногдох эд зүйлсийн тооллогыг статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас хэрэгжүүлэх аж ахуйн нэгж байгууллагын тооллоготой уялдуулан татварын алба, улсын бүртгэлийн байгууллага хамтран зохион байгуулна.

Дөрөв.Татвар төлөгчийг бүртгэлээс хасах

4.1.Татварын алба нь татвар төлөгчийг дараах үндэслэлээр татвар төлөгчийн бүртгэлээс хасна:

4.1.1.татвар төлөгч хувь хүнийг нас барсан болон нас барсанд тооцож татвар төлөх үүрэг дуусгавар болсон нь баримтаар нотлогдсон, Монгол Улсын иргэний харьяатаас гарах шийдвэр гарсан;

4.1.2.татвар төлөгч хуулийн этгээдийг татан буугдсан, дампуурсан тухай шүүхийн шийдвэр гарч, татвар төлөх үүрэг дуусгавар болж улсын бүртгэлээс хасагдсан;

4.1.3.Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн хуулийн этгээдийг татан буулгах тухай шийдвэр гарч, улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүй болгосон;

4.1.4.татвар төлөгч хуулийн этгээдийн эрхгүй байгууллагын хувьд уг байгууллагыг байгуулах шийдвэр гаргасан төрийн болон орон нутгийн байгууллага, гишүүдийн татан буулгах тухай шийдвэр.

4.2.Энэ журмын 4.1.2, 4.1.3, 4.1.4-т заасан нөхцөл үүссэн хуулийн этгээд, байгууллага нь татвар төлөгчийн бүртгэлээс хасуулах тухай хүсэлтээ цахим, эсхүл цаасан хэлбэрээр гаргах бөгөөд татварын алба дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.2.1.татвар төлөгчийн татварын эрсдэлийг тооцож, шаардлагатай тохиолдолд татварын хяналт шалгалтад хамруулах;

4.2.2.татварын өр, илүү үлдэгдлийг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх;

4.2.3.татан буугдах эрх бүхий байгууллага, гишүүдийн шийдвэр, шүүхийн шийдвэр, хяналт шалгалт, эрсдэлийн тооцооллын баримт бичиг, данс хаасан тухай мэдээлэл, санхүүгийн хаалтын тайлан зэрэг мэдээллийг бүрдүүлж хувийн хэрэгт хадгалах;

4.2.4.харьяалах татварын албаны бүртгэлийн асуудал хариуцсан нэгж нь "Татвар төлөгчийн бүртгэлээс хасах карт"-ыг хөтлөн, уг шийдвэрийг хянан баталгаажуулж, улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;

4.2.5.улсын бүртгэлээс хассан тухай бүртгэх байгууллагаас ирүүлсэн мэдээллийг үндэслэн татвар төлөгч хуулийн этгээдийг татвар төлөгчийн бүртгэлээс хасах;

4.2.6.татвар төлөгчийн бүртгэлээс хасагдсан тухай татвар төлөгчид мэдэгдэх.

4.3.Энэ журмын 4.2-т заасан үйл ажиллагааг хэрэгжүүлээгүй, татвар төлөх үүрэг дуусгавар болоогүй тохиолдолд “Татвар төлөгчийн хасалтын карт”-ыг хөтлөхийг хориглоно.

4.4.Шүүхийн шийдвэрийн дагуу татан буугдсан, дампуурсан татвар төлөгчийн хувьд уг шийдвэрийг үндэслэн татвар төлөгчийн бүртгэлээс хасах ажлыг харьяалах татварын алба зохион байгуулна.

4.5.Татварын ерөнхий хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т заасан нэгтгэх, нийлүүлэх, өөрчлөх замаар өөрчлөн байгуулсан хуулийн этгээдийг татвар төлөгчөөс хасахдаа татвар төлөгчийн татварын эрсдэлийг тооцож, татварын хяналт шалгалтад хамруулна.

4.6.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан мэдээлэлд үндэслэн татвар ногдуулалт, төлөлттэй холбогдсон эрх, үүрэг өөрчлөн байгуулагдсаны үр дүнд бий болсон хуулийн этгээдэд шилжих ба шилжиж буй татварын тооцооллын үлдэгдлийг тухайн татварын албаны даргын тушаалаар баталгаажуулан, ТБМНС-д мэдээллийг бүртгэнэ.

4.7.Татвар төлөгчийг бүртгэлээс хасахдаа энэхүү журамд заасан үйл ажиллагааг бүрэн хэрэгжүүлж, холбогдох баримтыг үндэслэн хасалтыг ТБМНС-д бүртгэнэ.

4.8.ТБМНС-д өөрчлөлт оруулах ажлыг татвар төлөгчийн харьяалах татварын албаны даргын тушаалаар, ажлын хэсэг гарган зохион байгуулж болно.



ТӨСӨЛ
/2019.08.29-ний өдөр/

Татвар төлөгчийн бүртгэлийн
журмын 1 дүгээр хавсралт

Монголын Татварын Алба

Маягт ТБ-01

ТАТВАР ТӨЛӨГЧИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар ...

Татвар төлөгч хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллагын мэдээлэл:

Нэр:	_____	Улсын харьяалал:	_____
Регистрийн дугаар:	_____	Өмчин хэлбэр:	_____
Татварын		Хариуцлагын	_____
төлөгчийн дугаар:	_____	хэлбэр:	_____
Харьяалагдах		Татвар төлөгчөөр	
татварын алба:	_____	бүртгэгдсэн огноо:	_____

Татвар төлөгч хуулийн этгээдийн удирдлагын мэдээлэл:

Татварын		Эцэг /эх/-ийн нэр:	_____
төлөгчийн дугаар:	_____	Нэр:	_____
Регистрийн дугаар:	_____	Ургийн овог:	_____

Татвар төлөгч хуулийн этгээдийн хаяг, холбоо барих мэдээлэл:

Аймаг дүүрэг:	_____	Утас:	_____
Сум, хороо:	_____	Факс:	_____
Баг, гудамж,	_____	Шуудангийн	_____
хороолол:		хайрцаг:	_____
Байшин	_____	И-мэйл хаяг:	_____
Хашаа, хаалга:	_____	Вэб хаяг:	_____

Татвар төлөгч хуулийн этгээдийн бүртгэгдсэн татварын төрлийн мэдээлэл:

Алба	Татварын төрөл	Бүртгүүлсэн огноо	Хасагдсан огноо
_____	_____	_____	_____
_____	_____	_____	_____
_____	_____	_____	_____
_____	_____	_____	_____





ТӨСӨЛ
/2019.08.29-ний өдөр/

Татвар төлөгчийн бүртгэлийн
журмын 2 дугаар хавсралт

Монголын Татварын Алба

Маягт ТБ-02

ТАТВАР ТӨЛӨГЧИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар ...

Татвар төлөгч хувь хүний мэдээлэл:

Нэр:	_____	Регистрийн дугаар:	_____
Эцэг /эх/-ийн нэр:	_____	Оршин суух төлөв:	_____
Ургийн овог:	_____	Иргэний харьяалал:	_____
Татварын төлөгчийн дугаар:	_____	Татвар төлөгчийг бүртгэсэн байдал*:	_____
Харьяалагдах татварын алба:	_____	Татвар төлөгчөөр бүртгэгдсэн огноо:	_____

* - Аж ахуй эрхлэгч, Суутган төлөгч, Хөрөнгийн албан татвар төлөгч ... гэх мэт

Татвар төлөгч хувь хүний хаяг, холбоо барих мэдээлэл:

Аймаг дүүрэг:	_____	Утас1:	_____
Сум, хороо:	_____	Утас2:	_____
Баг, гудамж, хороолол:	_____	Шуудангийн хайрцаг:	_____
Байшин	_____	И-мэйл хаяг:	_____
Хашаа, хаалга:	_____		

Татвар төлөгч хувь хүний бүртгэгдсэн татварын төрлийн мэдээлэл:

Алба	Татварын төрөл	Бүртгүүлсэн огноо	Хасагдсан огноо
_____	_____	_____	_____
_____	_____	_____	_____
_____	_____	_____	_____
_____	_____	_____	_____





Монголын Татварын Алба

Маягт ТБ-03

ТАТВАР ТӨЛӨГЧИЙН ХАСАЛТЫН КАРТ

Дугаар ...

Татвар төлөгч хуулийн этгээдийн мэдээлэл:

Нэр:

Регистрийн дугаар:

Татварын төлөгчийн дугаар:

Харьяалагдах татварын алба:

1	2	3	4	5	6	7	8
---	---	---	---	---	---	---	---

||| _____

Татвар төлөгчийн бүртгэлээс хасагдсан:

Шалтгаан:

Өөрчлөн зохион байгуулагдсан:

Шийдвэр:

Шийдвэрийн огноо:

Хянасан татварын улсын байцаагч:

Баталгаажуулсан татварын улсын ахлах байцаагч:

Төлөв:

Бүртгэлээс хасагдсан огноо:

--	--	--	--	--	--	--	--	--

Улсын бүртгэлээс хасагдсан:

Улсын бүртгэлийн байцаагч:

Улсын бүртгэлээс хасагдсан огноо:





Монголын Татварын Алба

Маягт ТБ-04

ТӨСӨЛ
/2019.08.29-ний өдөр/
Татвар төлөгчийн бүртгэлийн
журмын 4 дүгээр хавсралт

ТАТВАР ТӨЛӨГЧИЙН ХАСАЛТЫН КАРТ

Дугаар ...

Татвар төлөгч хувь хүний мэдээлэл:

Нэр: _____
Эцэг /эх/-ийн нэр: _____
Ургийн овог: _____
Иргэний харьяалал: _____
Регистрийн дугаар: _____
Татварын төлөгчийн дугаар: _____
Харьяалагдах татварын алба: _____

Татвар төлөгчийн бүртгэлээс хасагдсан:

Шалтгаан: _____
Өөрчлөн зохион байгуулагдсан: _____
Шийдвэр: _____
Шийдвэрийн огноо: _____
Хянасан татварын улсын байцаагч: _____
Баталгаажуулсан татварын улсын ахлах
байцаагч: _____
Төлөв: _____
Бүртгэлээс хасагдсан огноо: _____

Улсын бүртгэлээс хасагдсан:

Улсын бүртгэлийн байцаагч: _____
Улсын бүртгэлээс хасагдсан огноо: _____





Монголын Татварын Алба

Маягт ТБ-05

ТӨСӨЛ
/2019.08.29-ний өдөр/
Татвар төлөгчийн бүртгэлийн
журмын 5 дугаар хавсралт

ТАТВАРЫН ТӨРЛИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ КАРТ

Дугаар ...

Татвар төлөгчийн:

Нэр:

Регистрийн дугаар:

Татварын төлөгчийн дугаар:

Харьяалагдах татварын алба:

Татвар төлөгчийн бүртгэлээс хасагдсан:

Шалтгаан:

Шийдвэр:

Шийдвэрийн огноо:

Хасагдсан татварын төрөл:

Алба

Татварын төрөл

Хасагдсан
тайлантхугацаа

Хасагдсан
огноо





Монголын Татварын Алба

Маягт ТБ-06

ТӨСӨЛ
/2019.08.29-ний өдөр/
Татвар төлөгчийн бүртгэлийн
журмын 6 дугаар хавсралт

ТАТВАР ТӨЛӨГЧИЙН БҮРТГЭЛ – АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЭЦСИЙН ЭЗЭМШИГЧИЙН БҮРТГЭЛ

Дугаар ...

- Бүртгэлд хамрагдсан: он [][][][] сар [][] өдөр [][]
- Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн нэр:

- Хариуцлагын хэлбэр: [][][][][][]
- Хуулийн этгээдийн регистрийн дугаар: [][][][][][][][]
- Татвар төлөгчийн дугаар: [][][][][][][][][][][][][]
- Бүртгэх мэдээллийн төрөл: / “√” тэмдгээр тэмдэглэнэ /
 - ☐ Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмших
 - ☐ Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмших
- Бүртгэлийн хэлбэр: / “√” тэмдгээр тэмдэглэнэ /
 - ☐ Шинээр бүртгүүлэх
 - ☐ Нэмэлт, өөрчлөлтийг бүртгүүлэх
- Хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрх, ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн мэдээлэл:

8.2 Хуулийн этгээдийн ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн мэдээлэл:

№	Олгосон байгууллагын нэр	Тусгай зөвшөөрлийн дугаар	Тусгай зөвшөөрөл олгосон огноо	Тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа /жил/	Тусгай зөвшөөрлөөр олгосон талбайн хэмжээ /га/
1	2	3	4	5	6
Хайгуулын тусгай зөвшөөрөл:					
...					
...					
...					
Ашиглалтын тусгай зөвшөөрөл:					
...					
...					
...					



9. Газар эзэмших, ашиглах эрхтэй болон ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн эцсийн эзэмшигчийн хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийн мэдээлэл:

10. Эцсийн эзэмшигчийн хувьцаа, хувь оролцоогоороо төлөөлүүлэн удирдан чиглүүлж буй нэг болон түүнээс дээш үргэлжилсэн хэлхээ

№	Эцсийн эзэмшигчийн нэр	Улсын харьяалал	Оршин сууж буй хаягийн бүртгэл	Тухайн улс орны татвар төлөгчийн дугаар /болон түүнтэй дүйцэхүйц дугаар/		Хувь нийлүүлсэн хөрөнгийн мэдээлэл			
				Хувь хүн	Хуулийн этгээд	Хэмжээ /төг/	Хувь /%/	Хувьцааны тоо /ш/	Саналын эрх /нэгж/
1	2	3	4	5	6	7	8	9	10

холбоо бүхий хуулийн этгээдийн мэдээлэл /Сүүлийн шатны хэлхээ холбоо буюу эцсийн эзэмшигчээс эхлэн газар эзэмших, ашиглах эрхтэй болон ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийг оролцуулан үе шат бүрийн мэдээллийг бүртгэнэ./

Үе шат	Хөрөнгө оруулагч этгээдийн нэр	Улсын харьяалал	Бүртгэлийн дугаар /Тухайн улсын/	Хөрөнгө оруулалт авсан этгээдийн нэр	Хөрөнгө оруулалтын хувь	
					хувьцааны	Саналын эрхийн
1	2	3	4	5	6	7

Мэдээллийг үнэн зөв бүртгэсэн:
Хуулийн этгээдийн:
Гүйцэтгэх захирал: //
Гарын үсэг, тэмдэг нэр





Монголын Татварын Алба

Маягт ТБ-07

ТӨСӨЛ
/2019.08.29-ний өдөр/
Татвар төлөгчийн бүртгэлийн
журмын 7 дугаар хавсралт

ТАТВАР ТӨЛӨГЧИЙН БҮРТГЭЛ – ГАЗАР ЭЗЭМШИХ, АШИГЛАХ ЭРХ ЭЗЭМШИГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЭЦСИЙН ЭЗЭМШИГЧИЙН БҮРТГЭЛ

Дугаар ...

- Бүртгэлд хамрагдсан: он [][][][] сар [][] өдөр [][]
- Газар эзэмших, ашиглах эрх болон ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн нэр:

- Хариуцлагын хэлбэр: [][]
- Хуулийн этгээдийн регистрийн дугаар: [][][][][][][][]
- Татвар төлөгчийн дугаар: [][][][][][][][][][]
- Бүртгэх мэдээллийн төрөл: / “√” тэмдгээр тэмдэглэнэ /
☐ Газар эзэмших эрх
☐ Газар ашиглах эрх
- Бүртгэлийн хэлбэр: / “√” тэмдгээр тэмдэглэнэ /
☐ Шинээр бүртгүүлэх
☐ Нэмэлт, өөрчлөлтийг бүртгүүлэх
- Хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрх, ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн мэдээлэл:

8.1 Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний мэдээлэл:

№	Олгосон байгууллагын нэр	Гэрчилгээний дугаар	Нэгж талбарын дугаар	Гэрчилгээ олгосон огноо	Эрхийн хугацаа /жил/	Газрын байршил	Газрын хэмжээ /га/	Газрын зориулалт
1	2	3	4	5	6	7	8	9

8.2 Хуулийн этгээдийн ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн мэдээлэл:

№	Олгосон байгууллагын нэр	Тусгай зөвшөөрлийн дугаар	Тусгай зөвшөөрөл олгосон огноо	Тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа /жил/	Тусгай зөвшөөрлөөр олгосон талбайн хэмжээ/га/
1	2	3	4	5	6
Хайгуулын тусгай зөвшөөрөл:					
...					
Ашиглалтын тусгай зөвшөөрөл:					
...					



Я А Л У Д Э Я Э Ц О С Я А В Г Е С Э Ц О С Н Е С О Н А Г Л

9. Газар эзэмших, ашиглах эрхтэй болон ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн эцсийн эзэмшигчийн хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийн мэдээлэл:

10. Эцсийн эзэмшигчийн хувьцаа, хувь оролцоогоороо төлөөлүүлэн удирдан чиглүүлж буй нэг болон түүнээс дээш үргэлжилсэн хэлхээ

№	Эцсийн эзэмшигчийн нэр	Улсын харьяалал	Оршин сууж буй хаягийн бүртгэл	Тухайн улс орны татвар төлөгчийн дугаар /болон түүнтэй дүйцэхүйц дугаар/		Хувь нийлүүлсэн хөрөнгийн мэдээлэл			
				Хувь хүн	Хуулийн этгээд	Хэмжээ /төг/	Хувь /%/	Хувьцааны тоо /ш/	Саналын эрх /нэгж/
1	2	3	4	5	6	7	8	9	10

холбоо бүхий хуулийн этгээдийн мэдээлэл /**Сүүлийн шатны хэлхээ холбоо буюу эцсийн эзэмшигчээс эхлэн газар эзэмших, ашиглах эрхтэй болон ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийг оролцуулан үе шат бүрийн мэдээллийг бүртгэнэ.**/

Үе шат	Хөрөнгө оруулагч этгээдийн нэр	Улсын харьяалал	Бүртгэлийн дугаар /Тухайн улсын/	Хөрөнгө оруулалт авсан этгээдийн нэр	Хөрөнгө оруулалтын хувь	
					хувьцааны	Саналын эрхийн
1	2	3	4	5	6	7

Мэдээллийг үнэн зөв бүртгэсэн:
Хуулийн этгээдийн:
Гүйцэтгэх захирал: //
Гарын үсэг, тэмдэг нэр

